



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/548

Булган сум

Газрын байршил өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын иргэн Ж.Батжаргал /ГЮ68121372/-ын аймгийн Засаг даргын 2014 оны Б/60 дугаар захирамжаар Булган 5 дугаар баг Гурилын үйлдвэр-2 гудамжны 201а тоотод байршилтай 6308004237 нэгж талбарын дугаартай 200 м² газар нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн IX/19 дүгээр тогтоолоор баталсан Булган сумын шинэчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр автозам төлөвлөгдсөн тул газрын байршлийг Булган сум 6 дугаар баг С.Удвалын 1 дүгээр гудамж 6308008890 нэгж талбарын дугаартай газраас Төрийн банкны баруун талд шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2. Иргэн Ж.Батжаргалд газрын байршлыг өөрчлөн эзэмшүүлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын эзэмшиж буй 6308008890 нэгж талбарын дугаартай газрын хэмжээг 11677 м² болгож өөрчилсүгэй.

3. Ж.Батжаргал болон аймгийн Засаг даргын Тамгын газартай газар эзэмших гэрээг шинэчилэн байгуулж, гэрчилгээг олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /У.Бямбасүрэн/-т даалгасугай.

4. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн Ж.Батжаргал, аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Алтаншагай)-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны Б/60 дугаар захирамж, 2022 оны 76 дугаар захирамжийн аймгийн Засаг даргын Тамгын газартай холбогдох хэсгийг тус тус хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



8383010574